



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

**Улаанбаатар хот
2013 он**

ХУУЛЬЧДЫН АНХДУГААР ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 9 дүгээр
сарын 7-ны өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

Монголын Хуульчдын холбооны дүрэм батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.1 дэх заалт, Хуульчдын анхдугаар их хурлын хуралдааны дэгийн 16.1-д заасныг тус тус үндэслэн Хуульчдын Их хурлаас ТОГТООХ нь:

1. “Монголын Хуульчдын холбооны дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолыг 2013 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Б.БАТЦЭРЭН

АГУУЛГА

Нэгдүгээр бүлэг.	Нийтлэг үндэслэл	4
Хоёрдугаар бүлэг.	Хуульчдын холбооны гишүүний эрх зүйн байдал	4
Гуравдугаар бүлэг.	Хуульчдын холбооны Их хурал	7
Дөрөвдүгээр бүлэг.	Хуульчдын холбооны зөвлөл	9
Тавдугаар бүлэг.	Хуульчдын холбооны Ерөнхийлөгч	14
Зургадугаар бүлэг.	Тамгын газар	15
Долдугаар бүлэг.	Хяналтын зөвлөл	17
Наймдугаар бүлэг.	Хуульчдын холбооны хороод	20
Есдүгээр бүлэг.	Бусад	24

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

1. “Монголын Хуульчдын Холбоо” нь (цаашид “Хуульчдын холбоо” гэх) Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээр, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах, хуульчдын заавал гишүүнчлэлтэй, өөрөө удирдах ёсны, нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

2. Хуульчдын холбоо хуульчийн мэргэжлийн нэр хүнд, үйл ажиллагаа, хариуцлагын нэгдсэн стандарт тогтоож, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хуульчдын эрх ашгийг хамгаалах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3. Байгууллагын оноосон нэр: Монгол хэлээр “Монголын Хуульчдын холбоо”, Англи хэлээр “Mongolian Bar Association” гэж тус тус нэрлэнэ.

4. Хуульчдын холбоо нь Хуульчдын холбооны Зөвлөлөөс баталсан бэлгэ тэмдэг, албан хэргийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

5. Хуульчдын холбоо нь өөрийн тамга, тэмдэг, цахим хуудас, хэвлэл, банкинд харилцах данстай байна.

6. Хуульчдын холбоо нь “Хуульчдын холбоо нь Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Хуульчдын ордон 1701, Монголын Хуульчдын холбооны байр” хаягт байрлана.

[/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)

1.2 дугаар зүйл. Хуульчдын холбооны үйл ажиллагаа, түүнд баримтлах зарчим

1. Хуульчдын холбоо нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай, хуулиар хориглоогүй үйл ажиллагааг явуулна.

2. Хуульчдын холбооны эрхэм зорилго нь Монгол Улсад хуулийн засаглалыг төлөвшүүлэх, шударга ёсыг бэхжүүлэх нөхцөлийг хангахад оршино.

3. Хуульчдын холбоо нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, тэгш эрхийг эрхэмлэх, аливаа нам, улс төр, шашны үйл ажиллагаанаас ангид байх, хараат бус, бие даасан хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах, бүхий л үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулах, гишүүдээ мэргэжлийн хувьд байнга хөгжиж, суралцах явдлыг дэмжин хангах зарчмыг баримтална.

[/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)

4.Хуульчдын холбоо нь бүх гишүүддээ эрх тэгш үйлчлэх бөгөөд үйл ажиллагаандаа нийт гишүүдийн оролцоог хангаж ажиллахыг эрмэлзэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ГИШҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

2.1 дүгээр зүйл.Хуульчдын холбооны гишүүн

1.Хуульчдын холбоо заавал гишүүнчлэлтэй байх бөгөөд хуульч бүр гишүүн (цаашид “гишүүн” гэх) нь байна.

2.Холбооны гишүүний бүртгэлийг Тамгын газар хариуцаж, өөрчлөлт хөдөлгөөнийг шийдвэр гарснаас хойш ажлын хоёр хоногийн дотор хийнэ.

2.2 дугаар зүйл.Гишүүний эрх, үүрэг үүсэх

1.Хуульчдын холбооны гишүүдийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэнээр гишүүний эрх үүснэ.

2.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуульд заасан хугацаанд гишүүнээр элсэх өргөдөл гаргаагүй этгээд хүндэтгэн үзэх шалтгаан арилснаас хойш 30 хоногийн дотор хүсэлт гаргасан тохиолдолд Хуульчдын холбооны Зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) хурлаар хэлэлцэж, гишүүнээр бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

2.3 дугаар зүйл.Гишүүний эрх, үүрэг

1.Гишүүн нь дараах эрхтэй:

1.1.Хуульчдын холбооны үйл ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцох;

1.2.Хуульчдын холбооны удирдлага, бусад албан тушаалд өөрийн болон бусдын нэрийг дэвшүүлэх, сонгох, сонгогдох, томилогдон ажиллах, хуульд заасан үндэслэлээр болон өөрийн хүсэлтээр ажиллахаас татгалзах;

1.3.Хуульчдын холбооны үйл ажиллагаатай холбоотой журам, бусад шийдвэрийн төсөл санаачлах;

1.4.Хуульчдын холбооны үйл ажиллагааны талаар санал хүсэлтээ илэрхийлэх, гомдол гаргах, шийдвэрлүүлэх;

1.5.Хуульчдын холбооны удирдлага нь гишүүдийн нийтлэг эрх ашигт нийцээгүй шийдвэр гаргасан, үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл нийт гишүүдийн 5 хувийн дэмжлэг авснаар эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

1.6.Хуульчдын холбооны бүтцийн байгууллага нь гишүүдийнхээ нийтлэг эрх ашигт нийцээгүй шийдвэр гаргасан, үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл тухайн бүтцийн байгууллагын нийт гишүүдийн 5 хувийн дэмжлэг авснаар эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

1.7.Хуульчдын холбооны харьяалах бүтцийн байгууллагад хэлэлцэгдэж буй асуудлаар санал өгөх;

1.8.хууль, дүрэм, журамд заасан бусад эрх.

2.Гишүүн нь дараах үүргийг хүлээнэ:

2.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчдын холбооны дүрэм, Хуульчийн мэргэжлийн дүрэм болон Хуульчдын холбооноос гаргасан журмыг дагаж мөрдөх;

2.2.бусад гишүүдийнхээ эрхэлж байгаа ажил, албан тушаалтай нь холбогдуулан харилцан бие биедээ ямарч нөхцөлд нөлөөлөхгүй байх;

2.3. гишүүний татвар төлөх;

~~2.4.Хуульчдын холбооны үйл ажиллагаанд оролцох, Хуульчдын холбооноос гишүүнийх нь хувьд хүлээлгэсэн, хуульд нийцсэн, мэргэжлийн үйл ажиллагаанд хамааралгүй үүрэг, даалгаврыг биелүүлэх;~~

~~[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)~~

2.5.Хуульчдын холбооноос хүлээлгэсэн үүрэг, даалгаврыг биелүүлэх боломжгүй тохиолдолд үндэслэлээ тайлбарлах;

2.6.Хуульчдын холбооны аливаа албан тушаалд сонгогдох, томилогдохдоо сонирхлын зөрчлөө мэдүүлэх;

2.7.өөрийн үйл ажиллагааны улмаас Хуульчдын холбоонд учруулсан хохирлыг нөхөн төлөх.

2.8. Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг хангах;

~~[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)~~

2.9. Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хуульд заасан үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдээлэх;

~~[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)~~

2.10. Хуульчдын холбооны аливаа албан тушаалд сонгогдсон болон томилогдсон бол холбооноос үүрэгт ажлынх нь хувьд хүлээлгэсэн, хуульд нийцсэн үүрэг даалгаврыг биелүүлэх;

~~[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)~~

2.11. Хуульчдын нэгдсэн бүртгэл дэх мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэх;

~~[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)~~

2.4 дүгээр зүйл.Гишүүний эрх, үүрэг дуусгавар болох, түдгэлзүүлэх

1.Дараах тохиолдолд гишүүний эрх, үүрэг дуусгавар болно:

1.1.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болсон;

1.2.нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон.

2.Гишүүний эрх нь дуусгавар болсон болон түдгэлзүүлсэн этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас Хуульчдын холбоонд учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

~~[/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)~~

3.Дараах тохиолдолд гишүүний эрх, үүргийг түдгэлзүүлнэ:

~~3.1.Мэргэжлийн хариуцлагын хөрөөноос мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх хариуцлага хүлээлгэсэн;~~

~~[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)~~

3.2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.

~~[/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)~~

2.5 дугаар зүйл.Хуульчдын холбоо болон түүний гишүүнд хориглох зүйлс

1.Гишүүний үйл ажиллагаанд дараах зүйлсийг хориглоно:

1.1.өөрт эрх олгогдоогүй асуудлаар Хуульчдын холбоог төлөөлөх, мэдэгдэл хийх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх;

1.2.тодорхой албан тушаал эрхэлж буй гишүүний хувьд олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулах;

~~[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)~~

1.3.гишүүн нь ижил нэртэй байгууллага байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох;

1.4.улс төрийн болон шашны үйл ажиллагаа эрхлэх, сурталчлах;

1.5.хуульчдын холбоог хуваах, тусгаарлах, өөрчлөх, нэгтгэх, нийлүүлэх зорилгоор аливаа үйл ажиллагаа явуулах.

2.Энэ зүйлийн 1.4 нь Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

3.Хуульчдын холбоо дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- 3.1.Хуульчдын холбооны зорилгод нийцээгүй аливаа үйл ажиллагаа;
- 3.2.сонирхлын зөрчилтэй аливаа шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах;
- 3.3.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Хуульчдын холбооны нэрийн өмнөөс хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх.

4.Хуульчдын холбооны болон бүтцийн байгууллагын удирдлага, албан тушаалд сонгууль, томилгооны дагуу ажиллуулах эсвэл бусад асуудлаар шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлийг урьдчилан шалгаж, зөрчилтэй тохиолдолд хүчингүйд тооцно.

2.6 дугаар зүйл.Гишүүний татвар

1.Хуульчдын холбоо нь гишүүний татвартай байна. Гишүүний татварын хэмжээг Хуульчдын Их хурлаас (цаашид “Их хурал” гэх) тогтооно.

[/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)

2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 49.4 дүгээр зүйлд заасан хороо нь Хуульчдын холбооны гишүүний татвараас гадна тусдаа татвартай байж болно. Энэхүү татварын хэмжээ нь Хуульчдын холбооны татварын хэмжээнээс их байж болохгүй.

3.Хуульчдын холбооны гишүүний татварыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан Их хурал тогтооно.

4.Гишүүний татварыг сар бүр төлнө. Гишүүн өөрөө хүсвэл татварыг урьдчилан төлж болно. Энэ тохиолдолд татварын хэмжээнд өөрчлөлт орвол зөрүүг нөхөж тооцохгүй.

5.Татвар төлөх журам, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас татварын хөнгөлөлт үзүүлэх болон бусад асуудлыг Зөвлөл шийдвэрлэнэ. Зөвлөлийн шийдвэр нь тодорхой гишүүнд давуу байдал олгоогүй байна.

~~6.Мэргэжлийн хариуцлагын хөрөөнөөс хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх хариуцлага ногдуулсан хугацаанд гишүүний татвараас чөлөөлөхгүй.~~

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ИХ ХУРАЛ

3.1 дүгээр зүйл.Хуульчдын холбооны их хурал, түүний бүрэн эрх

1.Хуульчдын өөрөө удирдах ёсны эрх барих дээд байгууллага нь Хуульчдын Их хурал байна.

[/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)

2.Их хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 2.1.Хуульчдын холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 2.2.Хуульчийн мэргэжлийн дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

- 2.3.Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийг (цаашид “Ерөнхийлөгч” гэх) сонгох, чөлөөлөх, түүний цалингийн хэмжээг тогтоох;
- 2.4.Зөвлөлийн гишүүнийг батламжлах, чөлөөлөх;
- 2.5.~~Мэргэжлийн хариуцлагын хөрөө байгуулж, бүрэлдэхүүнийг батламжлах, чөлөөлөх;~~

[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)

- 2.6.Зөвлөлийн үйл ажиллагааны тайлан сонсох, зөвлөмж өгөх;
- 2.7.Хуульчдын холбооны гишүүний татварын хэмжээг тогтоох;
- 2.8.Хуульчдын холбоо, түүний бүтцийн байгууллагуудаас гаргах журмын нийтлэг журмыг тогтоох;
- 2.9.бусад бүрэн эрх.

3.2 дугаар зүйл.Ээлжит ба ээлжит бус Их хурал

1.Их хурлын ээлжит хурал хоёр жилд нэг удаа хуралдах бөгөөд Их хурал даргалагчаа сонгож, хурлын дэгээ тогтооно.

2.Хуульчдын холбооны ээлжит болон ээлжит бус Их хурлын тов болон хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хурал эхлэхээс 21 хоногийн өмнө Ерөнхийлөгч хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

3.Ээлжит Их хурлын хугацааг анхдугаар Их хурал хуралдсан хугацаанаас хойш тоолно.

4.Их хурал сонгогдсон төлөөлөгчдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

5.Их хурлаас гарах шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Их хуралд оролцож буй төлөөлөгчдийн олонхын саналаар тогтоол хүчин төгөлдөр болно. Тогтоолд хурал даргалагч гарын үсэг зурж, Хуульчдын холбооны тамгыг дарна.

6.Дараах тохиолдолд Зөвлөл болон Ерөнхийлөгч зөвшилцөн ээлжит бус Их хурлыг хуралдуулна:

- 6.1.Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;
- 6.2.Зөвлөлийн гишүүдийн 40 хувь нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;

~~6.3.Мэргэжлийн хариуцлагын хөрөөны гишүүдийн 40 хувь нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;~~

[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)

6.4.Хуульчдын холбооны нийт гишүүдийн 40 хувь нь ээлжит бус Их хурал хуралдуулахыг шаардсан;

6.5.Хяналтын зөвлөлөөс ээлжит бус Их хурал хуралдуулахыг шаардсан;

6.6.Зөвлөлийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувийн санал, шаардлагад үндэслэн зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын шийдвэрээр ээлжит бус Их хурал хуралдуулахыг шаардсан;

6.7.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4-т заасан хороодын тавиас дээш хувь нь шаардсан.

7.6.1, 6.2-т заасан тохиолдолд нөгөө этгээд нь хуралдуулна.

3.3 дугаар зүйл.Их хурлын төлөөлөгчдийн тоог тогтоох

1.Их хурлын төлөөлөгчдийн тоо нь хурал товлон зарлах шийдвэр гарах үед Хуульчдын холбоонд бүртгэлтэй байгаа нийт гишүүдийн арван хувьтай тэнцүү байна.

3.4 дүгээр зүйл.Төлөөлөгчийг сонгох журам

1.Их хурлын төлөөлөгч сонгох журмыг Хуульчдын холбооны гишүүдийн бүртгэлд үндэслэн эрх зүйн салбар, мэргэшлийн төлөөллийг тэнцвэртэй хангаж, дараах нийтлэг журамд нийцүүлэн Зөвлөл батална:

1.1.сонгуулийг хууль дээдлэх, ардчилсан ёсны, тэгш эрхийн, шударга ба ил тод байх зарчмуудыг баримтлан явуулна;

1.2.хуульч бүр сонгуульд нэр дэвших, сонгох, сонгогдох эрхтэй оролцоно;

1.3.гишүүн нь Их хурлын төлөөлөгчид зөвхөн өөрийгөө нэр дэвшүүлнэ;

1.4.Их хуралд оролцох хуульчдын төлөөллийг цахим сонгуулийн үндсэн дээр тодруулна.

3.5 дугаар зүйл.Их хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гаргах, санал оруулах

1.Зөвлөл Их хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батална.

2.Их хурал нь энэ дүрмийн 3.5 дугаар зүйлийн 3-т зааснаас бусад тохиолдолд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй.

3.Тухайн асуудлыг Их хурлаар хэлэлцүүлэхийг Зөвлөлөөс татгалзсан тохиолдолд төлөөлөгч энэхүү асуудлыг хэлэлцүүлэх саналыг Их хурлын үеэр гаргаж болно. Их хуралд оролцож буй нийт төлөөлөгчдийн дийлэнх олонхын дэмжлэг авснаар тухайн асуудлыг Их хурлаар хэлэлцэнэ.

3.6 дугаар зүйл.Санал хураалт

1.Хуульчдын холбооны удирдлага буюу Ерөнхийлөгч, Зөвлөлийн гишүүдийг сонгох, батламжлах, чөлөөлөх санал хураалтыг нууцаар явуулна.

2.Энэ дүрмийн 3.6 дугаар зүйлийн 1-д зааснаас бусад асуудлаарх санал хураалтыг илээр явуулна.

3.Их хуралд оролцож буй төлөөлөгчдийн хорин хувийн саналаар энэ дүрмийн 3.6 дугаар зүйлийн 2-т заасан асуудлаар санал хураалтыг нууцаар явуулж болно.

3.7 дугаар зүйл.Тооллогын комисс, түүний эрх, үүрэг

1.Тооллогын комиссыг Тамгын газар зохион байгуулна.

2.Тооллогын комисс дараах эрх, үүрэгтэй:

2.1.Их хурлын санал хураалтад оролцогчдын ирцийг тогтоож, хурлын даргалагчид мэдээлэх;

2.2.Их хуралд оролцож санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдох асуудалд тайлбар өгөх;

2.3.санал өгөх журмыг тайлбарлах;

2.4.санал өгөх журмын хэрэгжилт болон хуралд оролцогчдын санал өгөх эрхийг хангах;

2.5.санал хураалтыг санал авах хуудсаар явуулж байгаа тохиолдолд саналын хуудсыг тоолж, хүлээж авах;

2.6.санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх;

2.7.саналыг тоолж, дүнг нэгтгэн, энэ тухай шийдвэр гаргаж, санал хураалтын тооллогын комиссын даргын гарын үсгээр баталгаажуулан Их хуралд танилцуулах;

2.8.саналын хуудсыг Хуульчдын холбооны архивт хадгалуулахаар шилжүүлэх;

2.9.нууцаар санал хураах тохиолдолд төлөөлөгч саналаа чөлөөтэй өгөх нөхцөл, боломжийг бүрэн хангах ажлыг хэрэгжүүлэх;

3.Тамгын газар нь тооллогын явцтай холбоотой маргаан гарсан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл тооллогын комиссыг шинээр сонгож хяналтын тооллого хийлгүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛ

4.1 дүгээр зүйл.Хуульчдын холбооны зөвлөл

1.Зөвлөл нь Хуульчдын холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, бодлогыг тодорхойлох чиг үүрэгтэй хамтын удирдлагын байгууллага болно.

2.Зөвлөл нь үйл ажиллагааны тайлангаа Их хуралд тавих бөгөөд Их хурлаас гаргасан шийдвэр, зөвлөмжийг биелүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.

4.2 дугаар зүйл.Зөвлөлийн бүрэлдэхүүн

1.Зөвлөл нь гучаас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд эрх зүйн салбар, мэргэшил, болон тусгай асуудлаар сайн дураараа нэгдэж байгуулагдсан, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон энэ дүрэмд заасан шаардлагыг хангасан, Зөвлөлөөс батламжилсан хороодын төлөөлөл байна.

~~2.Зөвлөлийн бүрэлдэхүүнд энэ дүрмийн 4.2 дугаар зүйлийн 1-д заасан гишүүдээс гадна хууль зүйн сургуулийн оюутны болон хуульчийн шалгалт өгөхөөр мэргэжлийн дадлага хийж байгаа эрх зүйчдийн төлөөлөл тус тус нэг байна.~~

~~[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)~~

~~3.Хууль зүйн сургуулийн оюутны болон хуульчийн шалгалт өгөхөөр мэргэжлийн дадлага хийж байгаа эрх зүйчдийн төлөөллийг тэдгээрийн гаргасан хүсэлтийг үндэслэн Зөвлөл сонгоно.~~

~~[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)~~

4.Зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр оруулах тухай хорооны шийдвэрийг тухайн хороо Их хуралд хүргүүлнэ.

5.Их хурал нь зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр оруулах хорооны шийдвэр гаргах үйл ажиллагаа энэ дүрмийн 8.10 дугаар зүйлийн 3-т заасантай нийцсэн эсэхийг нягталж, холбогдох санал, гомдлыг шийдвэрлэсний үндсэн дээр Зөвлөлийн гишүүнээр батламжилна.

6.Зөвлөлийн гишүүнийг Их хуралд оролцсон нийт төлөөлөгчдийн тавиас доошгүй хувийн саналаар итгэл үзүүлсэн тохиолдолд батламжилж тогтоол гаргана.

7.Их хурал Зөвлөлийн гишүүнийг батламжлаагүй тохиолдолд санал болгосон хороо тухайн Их хурлын хугацаанд дахин өөр этгээдийг санал болгоно.

8.Зөвлөлийн гишүүн нь урамшуулалтай байх бөгөөд урамшууллын хэмжээг Тамгын газрын саналд үндэслэн Хяналтын зөвлөл тогтооно.

4.3 дугаар зүйл.Зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, үүрэг

1.Зөвлөлийн гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

- 1.1.гишүүний үүргийн ямар нэг зөрчилгүй байх;
- 1.2.сүүлийн гурван жил мэргэжлийн болон ёс зүйн хариуцлага хүлээгээгүй байх;
- 1.3.хуульчаар 3-аас доошгүй жил ажилласан байх;

~~[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)~~

1.4.сайн дурын зөвхөн нэг хорооноос нэрээ дэвшүүлэх ба тухайн хороондоо сүүлийн 3-аас доошгүй жил гишүүнчлэлтэй байх.

[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)

2.Зөвлөлийн гишүүн дараах үүрэг хүлээнэ:

2.1.зөвлөлийн хуралд оролцох;

2.2.хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж, бэлтгэсэн байх;

3.Зөвлөлийн тухайн жилийн нийт хурлын 50-аас дээш хувьд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй бол Зөвлөл уг гишүүнийг эгүүлэн татах шийдвэрийг гаргаж, энэ дүрмийн 4.5 дугаар зүйлийн 3-т заасны дагуу батламжлагдсан дараагийн гишүүнийг Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж, энэ тухай харьяалах хороонд мэдэгдэнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)

4.Энэ зүйлийн 4.3.1, 4.3.2-т заасан Зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, үүргээ зөрчсөн нь нэр дэвшигч болон Зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлсэн хороо эсвэл Зөвлөлийн хурлын шийдвэрээр эгүүлэн татах үндэслэл болно.

[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)

4.4 дүгээр зүйл.Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа

1.Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх ба нэг удаа улируулан ажиллуулж болно.

[/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)

4.5 дугаар зүйл.Зөвлөлийн гишүүний бүрэн эрх дуусгавар болох

1.Дараах тохиолдолд зөвлөлийн гишүүний бүрэн эрх дуусгавар болно:

1.1.гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

1.2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон;

1.3.санал болгосон хороо Зөвлөлийн гишүүнээс эгүүлэн татах шийдвэр гаргаж ирүүлсэн тохиолдолд;

1.4.Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөөр өөрөө хүсэлт гаргасан;

1.5.нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон;

1.6.зургаан сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх эсхүл суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон;

1.6.санал болгосон хороо нь татан буугдсан;

1.7.санал болгосон хорооны гишүүнчлэлийн тоо буурснаар Зөвлөлийн төлөөллийн тоонд өөрчлөлт орсонтой холбогдуулан гишүүнийг эгүүлэн татахаар шийдвэрлэсэн.

2.Дүрмийн 4.5 дугаар зүйлийн 1.7–д заасан тохиолдолд аль гишүүнээ эгүүлэн татах асуудлыг хороо өөрөө шийдвэрлэнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөлт оруулсан./](#)

3.Их хурлаас томилогдсон Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос өмнө Их хурал тухайн хорооны дараагийн гишүүнийг урьдчилан батламжилж бүрэн эрх хэрэгжиж эхлэх хугацааг заана.

4.Зөвлөлийн гишүүний бүрэн эрх нь дараагийн батламжлагдсан гишүүний бүрэн эрх хэрэгжиж эхэлснээр дуусгавар болно.

5.Энэ зүйлийн 3-т заасны дагуу батламжлагдсан дараагийн гишүүний бүрэн эрхийн хугацаа өмнөх гишүүний үлдсэн бүрэн эрхийн хугацаатай адил байна.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)

4.6 дугаар зүйл.Зөвлөлийн хурал

1.Зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

2.Зөвлөлийн хурлыг улирал бүрийн эхний сарын сүүлийн долоо хоногт багтаан Ерөнхийлөгч зарлан хуралдуулна.

3.Зөвлөлийн хурлыг Хуульчдын холбооны Ерөнхийлөгч даргална. Ерөнхийлөгч даргалах боломжгүй болсон тохиолдолд Зөвлөлийн гишүүдийн саналаар даргалагчийг сонгоно.

4.Зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

5.Зөвлөлийн хурлыг нээлттэй явуулж, шийдвэрийг Холбооны цахим хуудсанд ажлын хоёр хоногийн дотор байршуулж олон нийтэд мэдээлнэ.

4.7 дугаар зүйл.Зөвлөлийн хурлыг хуралдуулахыг шаардах

1.Дараах тохиолдолд Зөвлөл заавал хуралдана:

- 1.1.Зөвлөлийн нийт гишүүдийн арван таваас дээш хувь шаардлага гаргасан;
- 1.2.Ерөнхийлөгч дангаараа эсхүл Тамгын газар болон Чиг үүргийн хорооноос гаргасан саналыг Ерөнхийлөгч дэмжиж хурал хийхийг шаардсан;
- 1.3.Хяналтын зөвлөлөөс хурал хийхийг шаардсан.

2.Энэ зүйлийн 1-д заасан тохиолдолд Ерөнхийлөгч ажлын арван өдөрт багтаан зөвлөлийг хуралдуулна.

4.8 дугаар зүйл.Зөвлөлийн хурлын тов, хурал хүчин төгөлдөр болох

1.Зөвлөлийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.

2.Зөвлөлийн гишүүн нь хуралд биечлэн, хурлын зард тусгайлан заасан бол цахимаар оролцох үүрэгтэй. Саналын хуудсаар саналаа ирүүлсэн зөвлөлийн гишүүнийг зөвлөлийн хуралд оролцсонд тооцно.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмэлт оруулсан./](#)

3.Зөвлөлийн гишүүдийн олонх зөвлөлийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

4.Энэ дүрмийн энэ зүйлийн 3-т заасан хувь хүрээгүй бол зөвлөлийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг хурал даргалагч товлох бөгөөд энэ тохиолдолд хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглоно.

5.Тухайн асуудлаар зарлагдсан хурал нэр бүхий гишүүдийн ирцээс шалтгаалан 2 удаа хойшлогдсон тохиолдолд гишүүнийг эгүүлэн татаж, энэ дүрмийн 4.5. дугаар зүйлийн 3-т заасан журмаар батламжлагдсан орны төлөөллийг оролцуулан хийнэ.

6.Энэ дүрмийн 4.7. дугаар зүйлийн 2-т заасны дагуу зөвлөлийн хойшлогдсон хурлыг ажлын таван өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын гурван өдрийн өмнө зөвлөлийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

4.9 дүгээр зүйл.Зөвлөлийн хурлын зохион байгуулалт

1.Хуульчдын Холбоо нь Зөвлөлийн гишүүн хуралд оролцох санхүүгийн болон зохион байгуулалтын бололцоог хангах үүрэгтэй.

2.Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн хурлаас өмнө Зөвлөлийн гишүүн дараах баримт бичигтэй танилцах бололцоог Тамгын газар хангана:

2.1.Зөвлөлийн улирал, жилийн санхүүгийн тайлан;

2.2.санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;

2.3.Хуульчдын холбооны болон Тамгын газрын үйл ажиллагааны зардлын талаарх холбогдох баримт бичиг;

2.4.хэлэлцэх асуудалтай холбогдсон Зөвлөлийн гишүүдийн зайлшгүй танилцах шаардлагатай бусад баримт бичиг.

3.Зөвлөлийн хуралтай холбогдох Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон энэ дүрмээр зохицуулаагүй бусад асуудал болон хурлын дотоод дэгийг Зөвлөл өөрөө тогтооно.

4.10 дугаар зүйл.Зөвлөлийн гишүүн саналын эрхээ хэрэгжүүлэх, Зөвлөлийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

1.Зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

2.Зөвлөлийн хурлаар хэлэлцэж буй асуудлаар Зөвлөлийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгч зөвлөлийн хуралд саналын эрх эдэлнэ.

3.Зөвлөлийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд зөвлөлийн гишүүн нэг саналын эрх эдэлнэ.

4.Зөвлөлийн гишүүдийн хориос доошгүй хувь нь санал хураалтыг нууцаар явуулах тухай санал гаргавал нууцаар явуулна. Бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна.

5.Энэ дүрмийн 4.2. зүйлийн 2-т заасан зөвлөлийн гишүүн зөвлөлийн хуралд саналын эрхгүй оролцоно.

6.Ээлжит бус Их хурлыг хуралдуулах тухай асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

4.11 дүгээр зүйл.Зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гаргах, санал оруулах

1.Зөвлөлийн гишүүн болон Ерөнхийлөгч Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах, Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал гаргах эрхтэй.

2.Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хурал болохоос арван дөрөв хоногийн өмнө Зөвлөлийн нийт гишүүдийн тавиас дээш хувийн саналаар батална. Саналыг цахим болон бусад хэлбэрээр авч болно.

3.Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй.

4.Энэ зүйлийн 1-д заасан этгээд саналаа бичгээр гаргах бөгөөд түүнд гаргаж байгаа санал, түүний үндэслэл, санал оруулж байгаа этгээдийн нэр, албан тушаалыг тусгана.

5.Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд багтсан асуудлаарх судалгаа, танилцуулга болон холбогдох баримт бичгийг санал гаргасан этгээд Тамгын газартай хамтран боловсруулж хурал болохоос тав хоногийн өмнө Зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.

4.12 дугаар зүйл.Зөвлөлийн хурлын зар хүргэх

1.Зөвлөлийн хурал зарласан этгээд нь тухайн хурлын зарыг Тамгын газраар дамжуулан хуралд оролцох эрхтэй Зөвлөлийн гишүүдэд мэдээллэх үүрэг хүлээнэ.

2.Хурлын зард хурал хийх өдөр, цаг, газар, хуралд оролцох эрхтэй Зөвлөлийн гишүүдийн нэрсийн жагсаалт, хурлаар хэлэлцэх асуудал болон гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, бусад холбогдох мэдээллийг тусгасан байна.

3.Саналын хуудсаар санал урьдчилан авах тохиолдолд санал авах саналын хуудсыг хүлээн авах газар, сүүлчийн хугацааг тусгайлан мэдээлнэ.

4.13 дугаар зүйл.Зөвлөлийн бүрэн эрх

1.Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.Хуульчдын холбооны бодлогын баримт бичгийг боловсруулж, Их хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

1.2.Хуульчдын холбооны ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

1.3.Хуульчийн мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэж, Их хуралд оруулах, Хуульчийн мэргэжлийн дүрмийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх;

1.4.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан журмыг батлах;

1.5. ~~Мэргэжлийн хариуцлагын хорооноос бусад~~ Чиг үүргийн хороог байгуулж, тэргүүнийг нь хоёр жилийн хугацаатайгаар томилох;

[/2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас "Мэргэжлийн хариуцлагын хорооноос бусад" гэснийг хассан./](#)

1.6.чиг үүргийн хорооноос бусад хороог батламжлах;

1.7.Хуульчдын холбооны хяналтын зөвлөл /цаашид "Хяналтын зөвлөл" гэх/-ийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх;

1.8.Тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, түүний цалингийн хэмжээг тогтоох;

1.9.Тамгын газрын бүтэц, орон тоог батлах, ажилтны цалингийн хэмжээг тогтоох;

1.10.Хуульчдын холбооны төсөв, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, батлах;

1.11.аудитыг сонгох, түүнтэй гэрээлэх;

1.12.Хуульчдын холбооны орон нутаг дахь салбар, нэгжийг байгуулах, татан буулгах;

1.13.Хуульчдын холбооны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар хуульчдаас гаргасан өргөдлийг хэлэлцэж шийдвэрлэх, шаардлагатай бол Их хурлаар хэлэлцүүлэх;

1.14.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчдын холбооны дүрэм, Хуульчдын холбооноос баталсан журмын биелэлтэд хяналт тавих;

1.15.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон энэ дүрэмд зааснаас бусад Хуульчдын холбооны зохион байгуулалтын бүтцийг байгуулах, өөрчлөх, татан буулгах;

1.16. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)

1.17.чиг үүргийн хорооны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;
1.18.Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо (цаашид Шалгалтын хороо гэх)-ны бүрэлдэхүүнийг батлах;

1.19.Зөвлөхүүдийн зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, бүтэц, бүрэлдэхүүнийг батлах;

~~1.20.шүүгчид нэр дэвшигчийн талаарх дүгнэлтийг Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо (цаашид Ёс зүйн хороо гэх) болон Шалгалтын хорооны саналд үндэслэн гаргах;~~

~~[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)~~

1.21.шүүгч болон шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах асуудлаар Шүүхийн ерөнхий зөвлөлтэй харилцах;

~~1.22.Шүүхийн ёс зүйн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх асуудлаар Ёс зүйн хорооны саналыг хэлэлцэн шийдвэрлэх;~~

~~[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)~~

~~1.23.Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх асуудлаар Шалгалтын хорооны саналыг хэлэлцэн шийдвэрлэх;~~

~~[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)~~

~~1.24.Мэргэжлийн хариуцлагын хорооны ажиллах журмыг батлах.~~

~~[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)~~

2.Зөвлөл төсөв батлах болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ дүрэмд бүрэн эрх олгосноос бусад тохиолдолд санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

4.14 дүгээр зүйл.Зөвлөлийн хурал, түүний шийдвэрийн талаар гомдол гаргах

1.Хуульчдын холбооны бүтцийн байгууллага болон удирдах албан тушаалтны шийдвэрийн талаар гишүүний гаргасан гомдлыг энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

2.Хуульчдын холбооны дүрэм болон журмаар зохицуулсан асуудлын талаарх (дотогш чиглэсэн шийдвэр) гомдлыг Зөвлөл шийдвэрлэх ба энэ нь эцсийн шийдвэр байна. Шийдвэр гаргахтай холбогдуулан тогтоосон журам зөрчигдсөн, мэдэгдэх, оролцох эрх хангагдаагүй гэсэн үндэслэлээр гомдол гаргах эрхтэй.

3.Гишүүн нь хуулиар олгогдсон эрх хязгаарлагдсан гэж үзвэл гомдлоо зохих байгууллагад хандах замаар шийдвэрлүүлнэ.

4.Холбооны гишүүн биш этгээд нь тус холбоонд хандаж шаардлага, хүсэлт гаргах болон холбооны үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцох эрхгүй.

4.15 дугаар зүйл.Зөвлөлийн хурлын тэмдэглэл

1.Зөвлөлийн хурал дууссанаас хойш ажлын нэг өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, тэмдэглэл хөтлөгч болон хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.

2.Зөвлөлийн хурлын тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:

2.1.хурал болсон газар, он, сар, өдөр, цаг;

2.2.хурлын ирц;

2.3.хурлын дарга, оролцсон гишүүдийн нэр;

2.4.хурлаар хэлэлцсэн асуудал;

2.5.оролцогчдын гаргасан санал, дүгнэлт;

2.6.саналын хуудас хэрэглэсэн бол уг саналын хуудасны загвар;

2.7.хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол.

3.Зөвлөлийн хурлын тэмдэглэлд тоо, тооцоолол, огноо, дугаар, нэр зэрэг техникийн алдаатай гарсан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

4.Шаардлагатай гэж үзвэл зөвлөлийн хурлын тэмдэглэлийн үнэн зөвийн баталгаа болгож тодорхой техник хэрэгсэл ашиглан бичлэг хийж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

5.1 дүгээр зүйл.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч

1.Хуульчдын холбооны ерөнхийлөгч (цаашид “Ерөнхийлөгч” гэх)нь хуульчийн хувьд манлайлагч, хуульчдын нэр хүнд, ёс зүйн хувьд үлгэр дуурайлал үзүүлэгч, хуульчдыг байр суурь, бодлогын хувьд илэрхийлэгч болохын хувьд дараах шаардлагыг хангасан байна:

1.1.Хуульчдын дунд хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэжилтний хувьд бүрэн танигдсан;

1.2.Ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагын зөрчил гаргаж байгаагүй;

1.3.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг зургаагаас доошгүй жил эрхэлсэн;

1.4.Эрүүл мэндийн хувьд харшлах шалтгаангүй;

1.5.60 нас хүрээгүй эсхүл бүрэн эрхийн хугацаанд 60 нас хүрэхгүй байх

2.Их Хурлаас Ерөнхийлөгчийг сонгож, чөлөөлөх ба түүний цалингийн хэмжээг тогтооно.

3.Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх бөгөөд түүнийг улируулан сонгохгүй.

4. Ерөнхийлөгч сонгогдохдоо тодорхой мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн бол түүний биелэлтийг жил бүр Зөвлөлд тайлагнаж, дүнг Холбооны цахим хуудсанд байршуулан хуульчдад мэдээлнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)

5.2 дугаар зүйл.Ерөнхийлөгчийн бүрэн эрх

1.Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.Зөвлөлтэй зөвшилцөн Их хурлыг зарлан хуралдуулах;

1.2.Зөвлөлийн хуралдааныг даргалах;

1.3.Зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд саналын эрх эдлэх;

1.4.Хуульчдын холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;

1.5.Тамгын газрын даргад нэр дэвшүүлэх;

~~1.6.Шүүгчдийн хорооны удирдах зөвлөлөөс өргөн мэдүүлсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдээс ёс зүй, мэргэжлийн чадвар, хараат бусаар бие даан шийдвэр гаргах чадварыг шалгуур болгон сонгож, Монгол Улсын Ерөнхийлөгчид санал бэлгэх;~~

[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)

1.7.Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх чиг үүрэг бүхий магадлан итгэмжлэх комиссын дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

1.8.хууль болон энэ дүрмээр олгосон бусад бүрэн эрх.

2.Ерөнхийлөгч нь өөр ажил, албан тушаалыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

3.Ерөнхийлөгч нь Хуульчдын холбооны зорилгыг биелүүлэх асуудлаар тус холбооны бүтцийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Ерөнхийлөгч нь Хуульчдын холбооны захиргааны үйл ажиллагаанд оролцохгүй.

4.Шаардлагатай тохиолдолд Ерөнхийлөгчийн үүргийг Зөвлөлийн гишүүн орлон гүйцэтгэж болох бөгөөд энэ шийдвэрийг Ерөнхийлөгчийн хүсэлтээр Зөвлөл гаргана.

5.Ерөнхийлөгч албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Зөвлөлийн гишүүдийн саналаар Ерөнхийлөгчийн үүргийг орлон гүйцэтгэгчийг Зөвлөл сонгоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТАМГЫН ГАЗАР

6.1 дүгээр зүйл.Тамгын газар

1.Хуульчдын холбоо нь холбооны болон түүний Чиг үүргийн хороодын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, бусад хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Тамгын газартай байна.

2.Зөвлөл нь Тамгын газрын бүтэц, орон тоог баталж, ажилтны цалингийн хэмжээг тогтооно.

3.Тамгын газрын дарга болон бусад ажилтан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд байх бөгөөд хэрэв хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй бол уг зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

6.2 дугаар зүйл.Тамгын газрын чиг үүрэг

1.Тамгын газар нь Хуульчдын холбооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1.1.Хуульчдын холбооны хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулах;

1.2.Хуульчдын холбооны хүний нөөц, сургалт, хөгжил, ажилтнуудын нийгмийн асуудлыг зохион байгуулах;

1.3.Хуульчдын холбооны орон нутаг дах салбарыг арга зүйн удирдлагаар хангах;

1.4.Хуульчдын холбооны мэдээлэл, харилцаа, олон нийттэй харилцах асуудлыг эрхлэх;

1.5.өмгөөлөгчдийн нэр, хаягийн лавлагааг бэлтгэж хэвлэх.

1.6 Хууль тогтоомжид нийцүүлэн жил бүр Хуульчдын холбооны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэх”

[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)

6.3 дугаар зүйл.Тамгын газраас хороодтой харилцах

1.Тамгын газар нь бусад хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1.1.хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай нь холбогдуулан бусад байгууллагатай харилцахад холбоо тогтоож өгөх, шаардлагатай тохиолдолд Хуульчдын холбооны нэрийн өмнөөс албан бичиг хүргүүлэх;

1.2.зайлшгүй шаардлагатай тохиолдолд төсөв, санхүүгийн асуудлаар дэмжлэг үзүүлэх;

1.3.хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас хамааран тодорхой хугацаанд орон байраар хангах;

1.4.шаардлагатай бусад үйл ажиллагаа.

2.Тамгын газар нь бусад хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхдээ ялгавартай хандахгүй байх үүргийг хүлээнэ.

6.4 дүгээр зүйл. Чиг үүргийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулах

1.Тамгын газар нь Чиг үүргийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 1.1.Чиг үүргийн хороодын ажиллах орчин, нөхцлийг хангах;
- 1.2.ажлын хэрэгцээнд шаардлагатай хүний нөөц, техник, хэрэгсэл, бусад мэдээллээр хангах;
- 1.3.Чиг үүргийн хорооны үйл ажиллагааны талаар дүгнэлт, санал, зөвлөмж гаргах;
- 1.4.хуульчийн мэргэжлийн шалгалтын комиссын бүрэлдэхүүнд шалгалт хариуцсан ажилтанг ажиллуулах;
- 1.5.Улсын Их Хурлын хүсэлтээр хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх ажлыг зохих хороодтой хамтран зохион байгуулах.

6.5 дугаар зүйл. Тамгын газар, Зөвлөхүүдийн зөвлөлийн хамтын ажиллагаа

1.Хуульчдын холбоо бодлогын нөлөөллийн ажлыг зохион байгуулах асуудлыг Тамгын газраараа дамжуулан хэрэгжүүлэх ба түүний дэргэд Зөвлөхүүдийн зөвлөл ажиллана.

2.Зөвлөхүүдийн зөвлөлийн бүрэлдэхүүн одоо эрхэлж байгаа ажил нь давхар ажил эрхлэлтээр хязгаарлагдаагүй бол Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан хуульчдаас бүрдэнэ.

6.6 дугаар зүйл. Тамгын газрын дарга

1.Тамгын газрыг Тамгын газрын дарга удирдана.

2.Зөвлөл нь Тамгын газрын даргыг томилж, чөлөөлөх ба түүний цалингийн хэмжээг тогтооно.

3.Тамгын газрын дарга нь дараах бүрэн эрхтэй:

- 3.1.Хуульчдын холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл болон Их хурал, Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- 3.2.Зөвлөлөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд Хуульчдын холбоог төлөөлөн гадаад, дотоодын байгууллагатай харилцах, гэрээ, хэлэлцээр байгуулах
- 3.3.Хуульчдын холбооны орон нутаг дах салбарыг зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- 3.4.Зөвлөлөөс тогтоосон тодорхой үнийн дүнгээс дээшгүй хэлцлийг Хуульчдын холбоог төлөөлөн байгуулах.

6.7 дугаар зүйл. Тамгын газрын даргад тавигдах шаардлага

1.Тамгын газрын даргад нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:

- 1.1.санхүүгийн зохих түвшний мэдлэгтэй;
- 1.2.удирдах ажлын туршлагатай;
- 1.3.гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх.

6.8 дугаар зүйл. Тамгын газар үйл ажиллагаагаа тайлагнах

1.Тамгын газар нь хагас жилд нэг удаа Зөвлөлд ажлаа тайлагнана. Үйл ажиллагаагаа тайлагнахын өмнө дөчин таваас доошгүй хоногийн өмнө тайланг Хяналтын зөвлөлд хүргүүлэх бөгөөд Хяналтын зөвлөл нь тайлангийн талаар гаргасан дүгнэлтээ Зөвлөлд хүргүүлнэ.

2.Зөвлөлөөс Тамгын газрыг нэн даруй ажлаа тайлагнахыг шаардсан тохиолдолд Тамгын газар арваас доошгүй хоногийн өмнө Хяналтын зөвлөлд тайланг хүргүүлэх бөгөөд Хяналтын зөвлөл тайлангийн талаар гаргасан дүгнэлтээ Зөвлөлд хүргүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

7.1 дүгээр зүйл.Хяналтын зөвлөл

1.Хуульчдын холбоо нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу тус холбооны эд хөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх Хяналтын зөвлөлтэй байна.

2.“Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тухай” журмыг Хуульчдын холбооны зөвлөл батална.

7.2 дугаар зүйл.Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, байгуулах журам

1.Хяналтын зөвлөл нь хуульчдаас бүрдсэн таван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөлт оруулсан./](#)

2.Хяналтын зөвлөл нь даргатай байх ба түүнийг нийт гишүүдийн дотроос олонхын саналаар гурван жилийн хугацаагаар томилно.

3.Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүгчийн хоёр, прокурорын нэг, өмгөөлөгчдийн хоёр төлөөлөл байна.

4.Хяналтын зөвлөлийн гишүүдийг шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны санал болгосноор Хуульчдын холбооны зөвлөл томилж, чөлөөлнө.

7.3 дугаар зүйл.Хяналтын зөвлөлийн гишүүний үйл ажиллагаанд баримтлах зарчим

1.Хяналтын зөвлөлийн гишүүн нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримталж ажиллана:

- 1.1.Хуульчдын холбооны нэгдмэл эрх, ашиг сонирхлыг холбооны бүтцийн бусад байгууллагын эрх, ашиг сонирхлоос дээгүүр тавих;
- 1.2.үйл ажиллагаагаа хараат бус хэрэгжүүлж, аливаа нөлөөлөлд автахгүй байх;
- 1.3.үйл ажиллагаандаа үнэн зөв, шударга, бодитой хандах.

7.4 дүгээр зүйл.Хяналтын зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага

1.Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1.1.эдийн засаг, санхүүгийн зохих түвшний мэдлэгтэй байх;
- 1.2.сүүлийн зургаан жилийн хугацаанд Хуульчдын холбооны хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаагүй байх;
- 1.3.сүүлийн гурван жилийн хугацаанд Хуульчдын холбооны удирдлагад сонгогдон ажиллаж байгаагүй;
- 1.4.мэргэжлийн болон ёс зүйн зөрчлийн улмаас хариуцлага хүлээж байгаагүй байх.

2.Дараах хуульч Хуульчдын холбооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгогдохыг хориглоно:

- 2.1.Хуульчдын холбооны Ерөнхийлөгч;
- 2.2.Зөвлөлийн гишүүн;

2.3. орон нутаг дахь салбарын зохицуулагч;

2.4. Чиг үүргийн хорооны гишүүд.

7.5 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа

1. Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх ба 1 удаа улируулан сонгож болно.

[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)

2. Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд дараагийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.

7.6 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох

1. Дараах нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос нь өмнө чөлөөлж болохгүй:

1.1. өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөхөөр хүсэлт гаргасан;

1.2. Хяналтын зөвлөлийн гишүүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон;

1.3. эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүрэгт ажлаа 6 сараас дээш хугацаанд гүйцэтгэх боломжгүй болсон;

1.4. Хяналтын зөвлөлийн гишүүн нь Зөвлөлийн гишүүн болон Хуульчдын холбооны өөр бусад удирдах албан тушаалд томилогдсон;

1.5. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, цуцалсан;

1.6. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны өөр төрлийг эрхлэх болсонтой холбоотойгоор хууль тогтоомжид заасан шаардлага хангагдахгүйд хүрч байвал.

[/Энэ заалтад 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөлт оруулсан./](#)

1.7. Холбооны зөвлөлийн нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар чөлөөлөх шийдвэр гарсан

7.7 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн гишүүний урамшуулал

1. Хяналтын зөвлөлийн гишүүн нь Зөвлөлийн гишүүний нэгэн адил хэмжээний урамшуулал авч болно. Урамшууллын хэмжээг Тамгын газрын саналд үндэслэн Ерөнхийлөгч тогтооно.

7.8 дугаар зүйл. Хяналтын зөвлөлийн чиг үүрэг

1. Хяналтын зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1. Хуульчдын холбооны нягтлан бодох бүртгэл холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэх, санхүү, татварын болон бусад тайлан, санхүүгийн бусад мэдээлэл болон эд хөрөнгийн хуримтлал, зарцуулалтын үнэн бодит байдалд хяналт тавих;

1.2. Хуульчдын холбооны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, бусад мэдээлэлд тулгуурлан холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, зөвлөл дэх төлөөллийн зохистой байдал, дотоод мониторингийн тогтолцоог боловсронгуй болгох саналыг Их хуралд оруулах;

1.3. Хуульчдын холбооны орон нутаг дах салбарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих.

2. Хяналтын зөвлөл дээрх чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг явуулна:

2.1. Хуульчдын холбооны сар, улирал, жилийн санхүү, татварын болон бусад тайлан, тэнцлийг саадгүй авах, шалгах;

2.2.Хуульчдын холбооноос бусад этгээдтэй байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй байж болзошгүй хэлцлийг зохих журмын дагуу байгуулсан эсэхийг шалгах;

2.3.Хуульчдын холбооны хөрөнгө, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд холбогдох баримт бичгүүдийн бүрдэлт, бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, хөдөлгөөнд хяналт тавих;

2.4.санхүүгийн тухайн жилийн төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийг хянах.

7.9 дүгээр зүйл.Хяналтын зөвлөлийн эрх

1.Хяналтын зөвлөл үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ дараах эрхийг эдэлнэ:

1.1.Хуульчдын холбоо, түүний орон нутаг дахь салбарын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг шалгах, тэдгээрийн үйл ажиллагаанд хамааралтай аливаа баримт бичиг, цахим хэлбэрээр хөтөлсөн бүхий л баримт бичгүүдтэй танилцах, шаардан авах;

1.2.хяналт, шалгалтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай байгаа мэдээ, мэдээллийн талаар Хуульчдын холбооны удирдлага, албан тушаалтан, ажилтнаас тайлбар авах.

2.Шаардлагатай тохиолдолд Хяналтын зөвлөлийн аль нэг гишүүн нь Хяналтын зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар тусгайлан шинжээч хөлслөн авах эрхтэй. Шинжээчийг сонгох эрхийг санаачлага гаргасан гишүүн эдлэх бөгөөд зардлыг Хуульчдын холбоо эхний ээлжинд хариуцна. Хөндлөнгийн аудитын шалгалтаар шинжээчийн тогтоосон дүгнэлт батлагдсан тохиолдолд Хяналтын зөвлөлийн гишүүн зардлыг нөхөн төлөх үүрэг хүлээхгүй.

3.Зөвлөл, түүний гишүүн, Ерөнхийлөгч, Хуульчдын холбооны бусад удирдах албан тушаалтнууд Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, үүрэг, даалгавар өгөхийг хориглоно.

7.10 дугаар зүйл.Хяналтын зөвлөлийн үүрэг

1.Хяналтын зөвлөл нь дараах үүрэгтэй:

1.1.Хуульчдын холбооны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааны хяналт, шалгалтыг тогтмол хийх;

1.2.хийсэн шалгалтын ажлын үр дүн, тайланг тухай бүр болон жил бүрийн ажлын тайлангийн хамт бэлтгэн Зөвлөлд танилцуулах.

2.Их хурлын хооронд Хяналтын зөвлөлөөс хэрэгжүүлсэн хяналт шалгалтын бүхий л үйл ажиллагааны болон Хуульчдын холбооны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааны талаарх тайланг Их Хуралд танилцуулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХОРООД

8.1 дүгээр зүйл. Чиг үүргийн хороод

1.Хуульчдын холбоонд дор дурдсан чиг үүргийн хороод ажиллана:

1.1.Мэргэжлийн хариуцлагын хороо;

[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)

1.2.Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо;

1.3.Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо (цаашид Сургалтын хороо гэх);

1.4.Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо;

1.5.Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо (цаашид “Хуульчдын эрхийг хамгаалах хороо” гэх);

1.6.Хууль зүйн сургуулийн магадлан итгэмжлэх асуудал эрхэлсэн хороо (цаашид "Магадлан итгэмжлэлийн хороо" гэх);

1.7.Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хороо (цаашид "Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо" гэх).

2.Чиг үүргийн хороо Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон энэ дүрэмд заасан өөрийн эрхлэх асуудалд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.Чиг үүргийн хорооүйл ажиллагаагаа хуралдааны хэлбэрээр явуулах бөгөөд хорооны гишүүдийн олонх оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

4.Хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Санал тэнцсэн тохиолдолд хэлэлцэж буй асуудлыг хорооны тэргүүний саналаар шийдвэрлэнэ.

5.Хуралдаанд биечлэн оролцох боломжгүй гишүүн хэлэлцэх асуудлын талаар зөвхөн бичгээр саналаа ирүүлснийг хуралдаанд оролцож саналаа илэрхийлсэнд тооцно.

6.Чиг үүргийн хороодын үйл ажиллагаа явуулах нийтлэг журмыг Зөвлөл тогтооно.

7.Зөвлөл Чиг үүргийн хорооны гишүүнд нэр дэвшигчийг энэ дүрэмд зааснаас бусад үндэслэлээр татгалзахыг хориглоно.

8.~~Мэргэжлийн хариуцлагын хорооноос бусад~~ Чиг үүргийн хороог Зөвлөл байгуулж, тэргүүнийг хоёр жилийн хугацаагаар томилно.

[/2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас "Мэргэжлийн хариуцлагын хорооноос бусад" гэснийг хассан./](#)

~~8.2 дугаар зүйл.Мэргэжлийн хариуцлагын хороо, түүний бүрэн эрх~~

[/Энэ зүйлийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)

1.~~Мэргэжлийн хариуцлагын хороо нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, сахилга, ёс зүйн байдалд Хуульчдын хөлбөөны хүсэлтээр дүгнэлт гаргах, хуульч энэ хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн эсэх болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэн тухай маргаан (цаашид "маргаан" гэх) -ыг гомдлын дагуу хянан шийдвэрлэх, хуульчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.~~

2.~~Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнийг сонгох сонгуулийг цахим хэлбэрээр явуулна. Энэ дүрмийн энэ зүйлийн 4-т заасан шаардлагыг хангасан Хуульчдын хөлбөөны гишүүн тус хорооны гишүүнээр ажиллах хүсэлтээ илэрхийлэх эрхтэй.~~

3.~~Мэргэжлийн хариуцлагын хорооны шүүгч гишүүнд хүсэлтээ гаргасан хуульчдаас прокурор, өмгөөлөгчдийн хорооны гишүүд, прокурор гишүүнд шүүгч, өмгөөлөгчдийн хорооны гишүүд, өмгөөлөгч гишүүнд шүүгч, прокурорын хорооны гишүүд санал өгч, олонхын саналаар нэр дэвшүүлнэ.~~

4.~~Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнд дараах шаардлага хангасан хуульчийг нэр дэвшүүлнэ:~~

~~4.1.хуульчдын дунд нэр хүнд, ёс зүйн үлгэр дууриалал үзүүлэгч байх;~~

~~4.2.сүүлийн гурван жилийн хугацаанд мэргэжлийн үйл ажиллагааг тасралтгүй эрхэлсэн байх ба энэ хугацаандаа мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргасан үндэслэлээр хариуцлага хүлээж байгаагүй.~~

5. Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд тухайн гишүүнийг нэр дэвшүүлсэн хорооны дараагийн нэр дэвшигчийн бүрэн эрхийг Зөвлөл гишүүдийн дийлэнх олонхын саналаар хүлээн зөвшөөрч болно.

8.3 дугаар зүйл. Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо

1. Шалгалтын хороо нь хуульчийн шалгалт зохион байгуулах үүрэг бүхий Шалгалтын комисс байгуулах, хуульчийн шалгалт зохион байгуулах журам боловсруулж, Зөвлөлөөр батлуулах, хуульчийн шалгалтын зохион байгуулалт болон даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөхтэй холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэх болон энэ дүрэм, Хуульчдын холбооноос тогтоосон бусад дүрэм, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Шалгалтын хороо нь шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооноос тус бүр хоёр, хуульч профессоруудаас долоон төлөөлөл оролцсон нийт арван гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

3. Шалгалтын хорооны гишүүнд шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны Удирдах зөвлөлөөс, хуульч профессоруудыг магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуулиудаас тус тус нэр дэвшүүлнэ.

4. Дор дурдсан шаардлагыг хангасан хуульчийг Шалгалтын хорооны гишүүнд нэр дэвшүүлнэ:

- 4.1. мэргэжлээрээ наймаас доошгүй жил ажилласан;
- 4.2. эрх зүйн тодорхой салбараар таваас доошгүй жил мэргэшин ажилласан;
- 4.3. магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.

8.4 дүгээр зүйл. Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо

1. Сургалтын хороо нь хуульчдад зориулсан сургалтын бодлого, үндсэн чиглэл, хэлбэрийг тодорхойлж, хуульчийн үргэлжилсэн сургалтад зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хянаж хэлэлцэх, сургалт явуулах багш нарын талаар санал өгөх, сургалтын явц үр дүнгийн талаар дүгнэлт гаргах, үргэлжилсэн сургалтын багц цагийг тооцох аргачлал, журмыг боловсруулж, Зөвлөлөөр батлуулах болон энэ дүрэм, Хуульчдын холбооноос тогтоосон бусад дүрэм, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Сургалтын хороо нь шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооноос тус бүр хоёр, хуульч профессоруудаас долоон төлөөлөл оролцсон, нийт арван гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

3. Зөвлөл дор дурдсан шаардлагыг хангасан хуульчийг Сургалтын хорооны гишүүнээр батална:

- 3.1. мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан;
- 3.2. эрх зүйн тодорхой салбараар зургаагаас доошгүй жил мэргэшин ажилласан;
- 3.3. магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.

8.5 дугаар зүйл. Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо

1. Ёс зүйн хороо нь хуульчийн мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, Хуульчийн мэргэжлийн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх болон хуульчийн ёс зүйн сургалтыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулах, сургалтын үр дүнг тодорхойлох, хуульчийн ёс зүйн асуудлаар судалгаа хийх болон энэ дүрэм, Хуульчдын холбооноос тогтоосон бусад дүрэм, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Ёс зүйн хороо арван гурваас доошгүй гишүүнтэй байх бөгөөд хороонд гишүүнээр ажиллах хүсэлт ирүүлсэн хуульчдаас Зөвлөл сонгож, батална.

3. Ёс зүйн хорооны гишүүн нь дор дурдсан шаардлагыг хангасан байна:

3.1. сүүлийн гурван жилийн хугацаанд мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан үндэслэлээр хариуцлага хүлээж байгаагүй;

3.2. хуульчийн ёс зүйн асуудлаар хийсэн судалгаа, шинжилгээний ажил нь нийтийн хүртээл болсон.

4. Ёс зүйн хорооноос дүгнэлт гаргах, хорооны гишүүн шинжээчээр ажиллахтай холбогдсон харилцааг Зөвлөлөөс баталсан журмаар зохицуулна.

8.6 дугаар зүйл. Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо

1. Хуульчдын эрхийг хамгаалах хороо нь хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих замаар хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах болон энэ дүрэм, Хуульчдын холбооноос тогтоосон бусад дүрэм, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Хуульчдын эрхийг хамгаалах хороонд шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны төлөөлөл тус бүр гурав, энэ дүрмийн 8.12. дугаар зүйлийн 2-т заасан хороодын төлөөлөл дөрөв байх бөгөөд нийт арван гурван гишүүнтэй байна.

3. Хуульчдын эрхийг хамгаалах хорооны гишүүнд энэ дүрмийн 8.9. зүйлд заасан хороодын удирдах зөвлөлөөс нэр дэвшүүлнэ.

8.7 дугаар зүйл. Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх асуудлыг эрхэлсэн хороо

1. Магадлан итгэмжлэлийн хороо нь хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх журам, хууль зүйн сургуульд тавих нэгдсэн шаардлагыг боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах болон энэ дүрэм, Хуульчдын холбооноос тогтоосон бусад дүрэм, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Магадлан итгэмжлэлийн хороо нь Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хорооны гишүүд болон хуульч профессоруудын харилцан тэнцүү төлөөллөөс бүрдсэн арван гурван гишүүдтэй байна.

3. Магадлан итгэмжлэлийн хорооны бүрэлдэхүүнд магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургууль тус бүрээс нэг оюутны төлөөллийг оруулна. Эдгээр гишүүд нь саналын эрхгүй байна.

8.8 дугаар зүйл. Хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хороо

1. Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хороо нь хууль зүйн шинжлэх ухааны байгууллагын судлаач, эрдэмтэн, хууль зүйн сургуулийн багш хуульчдаас долоо, шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооны тус бүр хоёр төлөөллөөс бүрдсэн арван гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

2. Зөвлөл нэрлэсэн хороодын төлөөллийг гишүүнээр батална.

3. Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хорооны бусад гишүүнд энэ зүйлийн 1-д заасан шаардлага хангасан хуульч өөрийгөө нэр дэвшүүлнэ.

4. Зөвлөл хамгийн олон гишүүний санал авсан дарааллаар жагсааж эхний долоод жагссан хуульчийг гишүүнээр батална.

8.9 дүгээр зүйл. Сайн дурын хороод

1.Хуульчдын холбоо чиг үүргээ хороодоор дамжуулан хэрэгжүүлнэ. Хуульчдын холбооны гишүүд эрх зүйн салбар, мэргэшил болон тусгай асуудлаар сайн дураараа нэгдэж хороо байгуулж болно.

2.“Сайн дурын хороо” гэдэгт үндсэн хуулийн эрх зүй, захиргааны эрх зүй, иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүй, эдийн засгийн эрх зүй, хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны асуудлаар сайн дураар нэгдэж байгуулсан хороо болон чиг үүргийн хорооноос бусад Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэрлэн заасан хороо, Хуульчдын холбоонд хорооны эрхтэйгээр оролцож буй хуульчдын нэр хүнд, хариуцлагыг нэмэгдүүлэх, эрх ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагдсан төрийн бус байгууллагыг ойлгоно.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөлт оруулсан./](#)

8.10 дугаар зүйл. Эрх зүйн салбарын чиглэлээр байгуулагдах сайн дурын хороо

1.Хуульчдын холбоо нь эрх зүйн салбарын чиглэлээр үндсэн хуулийн, олон улсын, захиргааны, иргэний, эрүүгийн, эдийн засгийн эрх зүйн гэсэн зургаан салбар хороотой байна.

2.Энэ зүйлийн 1-д заасан эрх зүйн зургаан салбарт хамаарах бусад судалгааны чиглэл (дэд салбар, тусгай анги)-ээр байгуулсан хороо нь энэхүү зургаан салбар хороодын дотоод бүтцийн байгууллага буюу дэд хороо байх бөгөөд бие дааж сайн дурын хорооны эрх эдлэхгүй. Дэд хороодыг тухайн салбар хорооны удирдах зөвлөлийн шийдвэрээр батламжилна.

3.Эрх зүйн салбарын чиглэлээр байгуулагдсан хороо нь Зөвлөлд төлөөлөгч илгээхдээ шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчдын төлөөллийн тэнцвэрийг хангана.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас хүчингүй болсонд тооцсон./](#)

8.11 дүгээр зүйл. Мэргэшлийн чиглэлээр байгуулагдах сайн дурын хороо

1.Хуульчдын холбоо нь хуульчийн мэргэшлийн чиглэлээр шүүгчдийн, прокурорын, өмгөөлөгчдийн хороотой байна.

8.12 дугаар зүйл. Эрх зүйн тусгай асуудлын чиглэлээр байгуулагдах сайн дурын хороо

1.Хуульчдын холбоо нь нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудлаар сайн дураар нэгдэж байгуулсан хороотой байна.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөн найруулсан./](#)

2.Хуульчдын нэр хүнд, хариуцлагыг нэмэгдүүлэх, эрх ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор сайн дураар нэгдэж байгуулагдсан төрийн бус байгууллага нь Хуульчдын холбоонд хорооны эрхтэйгээр оролцож болно.

3.Холбооны нийгмийн хариуцлага, залгамж чанар, гишүүдийн мэргэшил, хөгжлийн чиг хандлагыг хөгжүүлэх зорилгоор сайн дурын хороо байгуулж болно.

[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)

8.13 дугаар зүйл. Сайн дурын хороонд тавигдах шаардлага

1.Сайн дурын хороо нь Хуульчдын холбооны чиг үүргийг хэрэгжүүлэгч болохын хувьд дараах шаардлага хангасан байна:

1.1.үйл ажиллагаа нь Чиг үүргийн хорооны үйл ажиллагаатай зөрчилдөхгүй байх;

1.2.Чиг үүргийн хороод, хуульд нэрлэн заасан шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хороотой болон өөр хоорондоо оноосон нэр, түүнийг тодорхойлж байгаа эрх зүйн салбар мэргэшил, тусгай сонирхлын хувьд давхцахгүй байх;

1.3.Хороонд нэгдсэн гишүүдийн тоо хориос доошгүй байх.

2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэрлэн заасан шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооноос бусад байдлаар хуульчийн эрхэлж буй ажил, мэргэшлээр хуваагдсан гишүүнчлэл бүхий хороог Зөвлөл батламжлахгүй. Шүүгч нь Шүүгчдийн хорооны, прокурор нь Прокурорын хорооны, өмгөөлөгч нь Өмгөөлөгчдийн хороодын гишүүн байна.

8.14 дүгээр зүйл.Сайн дурын хороодыг батламжлах

1.Хороо байгуулж буй гишүүд тэдгээрийн байгуулсан хороо нь хууль болон дүрмээр тогтоосон шаардлагыг бүрэн хангасныг илтгэх танилцуулга, оноосон нэр, эрх зүйн салбар, мэргэшил, тусгай асуудлыг сонгож хороог байгуулсан шийдвэр, гишүүдийн бүртгэл зэргийг батламжлуулах хүсэлтдээ хавсаргана.

2.Батламжлуулахаар ирүүлсэн сайн дурын хороод нь өөр хоорондоо оноосон нэр, түүнийг тодорхойлж байгаа эрх зүйн салбар мэргэшил, тусгай асуудлын хувьд давхцсан тохиолдолд тэдгээрийг нэгтгэсэн гишүүнчлэл бүхий нэг хороо болж зохион байгуулагдсаны дараа түүнийг батламжилна.

3.Хууль болон дүрэмд заасан шаардлагыг хангаагүй хороог Зөвлөл батламжлахгүй. Батламжлагдаагүй хороог байгуулагдсанд тооцохгүй.

8.15 дугаар зүйл.Хорооны гишүүнд тавигдах шаардлага

1.Сайн дурын хорооны гишүүнд дараах шаардлага тавигдана:

1.1.тухайн салбар мэргэшил, тусгай асуудлаар мэргэшин ажиллах сонирхолтой;

1.2.уг хорооны гишүүн болсноор тухайн гишүүн нь гурваас илүүгүй сайн дурын хороонд, нийт таваас илүүгүй чиг үүргийн болон сайн дурын хорооны харьяалалтай байх.

8.16 дугаар зүйл.Сайн дурын хорооны зохион байгуулалт

1.Хороо нь тэргүүн болон гурваас арван хоёр хүртэлх тооны гишүүнээс бүрдэх Удирдах зөвлөлтэй байна.

2.Сайн дурын хороодын зохион байгуулалттай холбоотой нийтлэг журмыг энэ дүрмийн зохицуулалттай нийцүүлэн Зөвлөл батална.

3.Мэргэшлийн чиглэлээр байгуулагдах хорооноос бусад сайн дурын хороо Хуульчдын холбооны гишүүний татвараас гадна тусдаа татвартай байж болно. Уг татвар нь Хуульчдын холбооны татвараас илүүгүй хэмжээтэй байна.

4.Сайн дурын хорооны татвар нь гишүүнчлэлийн зэрэглэлийн хэлбэртэй байж болох бөгөөд сайн дурын байна.

[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)

5.Бие даасан сайн дурын хороо тус бүр нэг төлөөллөө дотроосоо сонгон Зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр оруулах бөгөөд хорооны гишүүдийн тоо 50 ба түүнээс дээш бол хоёр, 100 ба түүнээс дээш бол нь гурав, 200 ба түүнээс дээш бол дөрвөн гишүүнийг тус бүр төлөөлөгчөөр сонгон Зөвлөлд бүрэлдэхүүнд оруулахаар Их хуралд хүргүүлнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнд орох нэг хорооны төлөөллийн дээд хязгаар дөрөв байна.

6.Хороо үйл ажиллагаагаа хангалттай явуулахгүй байна гэж үзвэл тухайн хорооны нийт гишүүдийн 10-аас доошгүй хувь нь нэгдэн хорооны тэргүүн, удирдах зөвлөлийг тараах, чөлөөлөх саналыг холбооны Ерөнхийлөгчид гаргаж болох бөгөөд Ерөнхийлөгч үндэслэлтэй гэж үзвэл Зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)

7.Сайн дурын хороод нь Зөвлөлөөс зөвшөөрсөн нөхцөлд өөрийн хорооны эрхлэн хариуцсан үйл ажиллагааны чиглэлд нийцэх төсөл хөтөлбөрийг гадаад, дотоодын байгууллага, хувь хүнтэй хамтран хэрэгжүүлж болно. Хамтарсан төсөл хэрэгжүүлэх зорилгоор хандив, грант авах замаар холбогдох үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж болох ба Хуульчдын холбооны үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд баримтлах хууль тогтоомжид нийцсэн байна.

[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)

8.Сайн дурын хороод Хуульчдын холбооны үндсэн үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн Хуульчдын холбоог нийгэмд таниулан сурталчлах, гишүүн хуульчдын мэргэжлийн үйл ажиллагааны хүртээмжийг дэмжих зорилготой мерчандайз бүтээгдэхүүн гаргах, үзэсгэлэн экспо зохион байгуулах, гарын авлага, товхимол гаргах зэргээр үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж болно.

[/Энэ заалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Хуульчдын Их хурлаас нэмсэн./](#)

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД

9.1 дүгээр зүйл.Хуульчдын холбооны салбар, нэгж

1.Хуульчдын холбоо нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор орон нутагт салбар, нэгж байгуулан ажиллуулж болно. Салбар, нэгжийн үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулах журмыг Зөвлөл батална.

2.Салбар, нэгжийг байгуулах, татан буулгах асуудлыг Зөвлөл шийдвэрлэнэ.

3.Хуульчдын холбооны салбар, нэгж нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд өөрийн харилцах данстай байж болно. Салбар, нэгжийн харилцах данс нь Хуульчдын холбооны данс байна.

9.2 дугаар зүйл.Хуульчдын холбооны хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах

1.Хуульчдын холбооны Их хурлын болон Зөвлөлийн тогтоол, цаг үеийн асуудлаар гаргасан мэдэгдэл, байр суурийг Ерөнхийлөгч Хуульчдын холбоог төлөөлөн илэрхийлнэ.

2.Холбоо нь өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байж болно. Холбогдох журмыг Зөвлөл батална.

9.2 дугаар зүйл.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа

1.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон зохион байгуулалтын ажлыг Тамгын газар хариуцах бөгөөд үүнтэй холбогдох зардлын төсвийг жил бүр Хуульчдын холбооны төсөвт тусгаж байна. Тамгын газар нь жил тутам хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан хуульчдын талаар олон нийтэд мэдээлж байна.

9.4 дүгээр зүйл.Бодлогын нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагаа

1.Хуульчдын холбоо бодлогын нөлөөллийн ажлыг зохион байгуулах асуудлыг Тамгын газраараа дамжуулан хэрэгжүүлэх ба түүний дэргэд Зөвлөхүүдийн зөвлөл ажиллана.

2.Хуульчдын холбоо дэргэдээ бодлогын асуудлаар дэмжлэг үзүүлэх судалгаа, шинжилгээний бүтэцтэй байж болно. Энэ бүтэц нь Зөвлөхүүдийн зөвлөлийн удирдлага дор ажиллана.

3.Зөвлөхүүдийн зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, бүтэц, бүрэлдэхүүнийг Зөвлөл батална.

9.5 дугаар зүйл.Хуульчдын холбоо бусад байгууллагатай харилцах

1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний

1.1.харьяа байгууллага нь Хуульчдын холбоотой дараах байдлаар харилцаж ажиллана:

1.2.хуульчийн мэргэжлийн шалгалтын комиссын бүрэлдэхүүнд төлөөлөгч оролцуулах;

1.3.хууль зүйн нэгдсэн бодлогын болон бусад асуудлаар судалгаа, шинжилгээний ажлыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа судалгааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, хуулийн төслийн үзэл баримтлалын төвшинд мэргэжлийн шинжээчээр Холбооны төлөөллийг оролцуулах;

1.4.Холбоо нь хууль зүйн сургуулийн магадлан итгэмжлэлийн ажлын тайланг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад энэ талаар тайлбар, тодруулга хүргүүлэх;

1.5.хуульчийн үргэлжилсэн сургалтын бодлого, үндсэн чиглэл, хэлбэрийг тодорхойлохдоо Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа сургалтын асуудал эрхэлсэн зохих байгууллагын саналыг авах буюу төлөөллийг оролцуулах;

1.6.хууль болон Холбооны дүрэмд харшлаагүй бусад үйл ажиллагаа.

2.Хуульчдын холбоо УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар 2 жил тутам Их хурал хуралдахаас өмнө мэдээлэл хүргүүлж, дүгнэлт, зөвлөмж гаргуулсан байна. Ээлжит бус их хурал зарлагдах үед Хууль зүйн байнгын хороо шаардвал мэдээллийг хүргүүлнэ. Хууль зүйн байнгын хорооны дүгнэлт, зөвлөмж нь заавал дагаж мөрдөх шинжийг агуулахгүй.

3.Хуульчдын холбоо нь бусад байгууллагатай өөрийн чиг үүрэг, бие даасан байдалд харшлахгүйгээр хамтран ажиллаж болно.

9.6 дугаар зүйл.Хуульчдын холбооны шагнал, урамшуулал

1.Хуульчдын холбоо нь шагнал, урамшуулалтай байж болох бөгөөд холбогдох харилцааг Зөвлөл журмаар зохицуулна.

2.Хуульчдын холбоо нь дангаараа болон бусад байгууллагатай хамтран хуульчдын нэр хүндийг өргөх, хүлээн зөвшөөрөх, урамшуулах зорилгоор дараах шагнал, урамшууллыг жилд нэг удаа олгоно:

2.1.Хуульчдын танхимд хууль зүйн салбарын нэр хүндтэй, ахмад хуульчдын хөргийг хүндэтгэлтэйгээр байрлуулах;

2.2.“Про-боно хуульч” шагнал;

2.3.Хууль зүйн шинжлэх ухааны шилдэг бүтээл.

9.7 дугаар зүйл.Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

1.Хуульчдын холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Их хуралд оролцож буй төлөөлөгчдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

9.8 дугаар зүйл.Хуульчдийн холбоо, түүний бүтцийн байгууллагад сонгууль явуулах нийтлэг журам

1.Хуульчдын холбоо, түүний бүтцийн байгууллагын сонгууль нь шударга, маргаангүй байх үүднээс дараах шаардлагыг хангасан байна:

1.1.нийт гишүүдэд сонгуулийн товыг хангалттай хугацааны өмнө, тохиромжтой хэлбэрээр мэдэгдсэн байх;

1.2.сонгууль явуулах журмыг тодорхой зарлаж мэдэгдсэн байх;

1.3.нэр дэвших, дэвшүүлэх хугацаа, бусад боломжоор хангасан байх;

1.4 нийт гишүүдийн олонх оролцсоноор сонгуулийн ирцийг хүчинтэйд тооцох;

2.Сонгуулийг цахим хэлбэрээр, саналаа чөлөөтэй өгөх эрхийг хангасан байдлаар явуулж болно.

3.Бүтцийн байгууллага нь удирдах зөвлөл, тэргүүний сонгууль болон бусад шаардлагатай асуудлаар санал хураалтыг нууцаар явуулна.

4.Санал хураалт илээр явуулж буй тохиолдолд тухайн асуудлаар эсрэг саналтай байгаа гишүүдийн саналыг эхэлж авна.

5.Сонгуульд оролцох эрх бүхий гишүүн саналаа биечлэн өгөх бөгөөд бусдын нэрийн өмнөөс санал өгөх болон итгэмжлэлээр төлөөлөн санал өгөхийг хориглоно.

6.Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар зориудаар хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно.

7.Ирцэд бүртгэгдэж, сонгуульд оролцож буй гишүүн нь санал хураалтад оролцоогүй (санал өгөөгүй) тохиолдолд хэлэлцэж буй асуудлаар дэмжсэн санал өгсөнд тооцно. Харин хуралдаанд зориудаар оролцоогүй буюу хурал орхиж гарсан тохиолдолд эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.

8.Шүүх, прокурор болон бусад хуулийн байгууллагуудын захиргааны зүгээс Хуульчдын холбооны сонгуулийн үйл ажиллагаанд зохион байгуулалттайгаар оролцох, хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

9.9 дүгээр зүйл.Хуульчдын холбооны бүтцийн байгууллагаас гаргах журамд тавигдах нийтлэг зохицуулалт

1.Зөвхөн хууль, дүрмээр тухайн этгээдэд эрх олгогдсон асуудлаар журам гаргана.

2.Хууль болон дүрмээр тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар гаргасан журмыг дагаж мөрдөхгүй.

3.Хууль болон дүрмээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрх бүхий этгээд нь журам гаргах эрхээ доод шатны этгээд, албан тушаалтанд шилжүүлж болохгүй.

4.Журам нь хууль болон дүрмээр олгогдсон гишүүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулж болохгүй.

5.Хууль тогтоомж, дүрмийн зүйл, заалтыг хуулбарлан давхардуулан зохицуулахыг хориглоно.

6.Журмын заалт нь хоорондоо болон эрх бүхий бусад этгээдийн гаргасан журмын заалттай зөрчилдөхгүй байна.

7.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчдын холбооны дүрэмд заагаагүй үүргийг гишүүнд ногдуулахаар зохицуулахыг хориглоно.

8.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчдын холбооны дүрмээр хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохыг хориглоно.

9.Журмыг батлан гаргасан этгээд болон журмын нэр, огноо, дугаар, дагаж мөрдөх хугацааг тодорхой заана.

10.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчдын холбооны дүрэмд хэрэглэсэн нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэнэ.

11.Хэл найруулга нь товч тодорхой, монгол хэлний зөв бичих дүрмийн дагуу, хоёрдмол утгагүй, ойлгоход хялбар байдлаар бичигдэнэ. "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-д заасан баримт бичиг зохион бүрдүүлэх шаардлагыг хангасан байна.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хуульчдын Их хурлаас өөрчлөлт оруулсан./](#)

12.Тухайн журмаар өмнө нь гарсан журмыг хүчингүй болсонд тооцож байгаа, эсхүл түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бол энэ тухай заалтыг заавал тусгана.

13.Тухайн журмаар зохицуулагдаж буй асуудлаар эрх ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд мэдэгдэж, санал өгөх оролцоог нь хангана.

9.10 дугаар зүйл.Шилжилтийн зохицуулалт

1.Хуульч нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу байгуулагдсан, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Хуульчдын холбоонд заавал гишүүнчлэлтэй байх тул ижил нэртэй өөр байгууллага байгуулах, гишүүнээр элсэх, үйл ажиллагаанд нь оролцохыг хориглоно.

2.Хуульчдын холбооны дүрэм батлагдсанаар Хуульчдын холбоог байгуулагдсанд тооцож, Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр эрх зүйн харилцаанд оролцох эрх зүйн чадвартай болно. Ерөнхийлөгч анхдугаар хуралдаан дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор Хуульчдын холбоог Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулна.

3.Зөвлөл байгуулагдахаас өмнөх сайн дурын хороо батламжуулах хүсэлтийг анхдугаар Их хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ. Анхдугаар Их хурлаас сайн дурын хороог батламжлуулах хүсэлт, холбогдох баримт бичиг нь энэ дүрмийн 8.13, 8.14 зүйлд заасан нөхцөл, шаардлага хангагдсан эсэхийг нягтлан шалгаж, Их хуралд танилцуулан шийдвэрлүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулна.

4.Энэ зүйлийн 3–т заасан Ажлын хэсэг нь Зөвлөл байгуулагдахаас өмнөх сайн дурын хороо байгуулах хүсэлтийг хүлээн авч, сайн дурын хороод байгуулах, зохион байгуулалтад орох асуудлаар арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж, дүрэмд заасан шаардлага хангасан хороодын нэрсийг www.jurists.gov.mn цахим системд оруулах ажлыг хариуцна. Зөвлөл байгуулагдахаас өмнөх сайн дурын хороодын Удирдах зөвлөлийн гишүүдийн тоог Ажлын хэсэг тогтооно.

5.Холбооны дүрмийн 8.9 дугаар зүйлийн 1, 8.10 дугаар зүйлийн 1, 8.11 дүгээр зүйлд заасан сайн дурын хороод болон шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн нэрлэсэн хороодын гишүүнчлэлийг бүртгэх, удирдах зөвлөл, тэргүүн, Хуульчдын холбооны зөвлөлд илгээх төлөөлөгчдийн нэрсийг сонгох ажлыг www.jurists.gov.mn цахим системийн тусламжтайгаар явуулна.

6.Хороо болон Хуульчдын холбооны зөвлөлд илгээх төлөөллийг батламжлуулах хүсэлтийг тус тусын хороодын Удирдах зөвлөл нь энэ зүйлийн 3–т заасан Ажлын хэсэгтэй хамтран гаргаж Хуульчдын холбооны анхдугаар Их хурлын хугацаанд ирүүлнэ.

7.Энэ дүрмийн 4.13 дугаар зүйлийн 1.23 дугаар заалтыг 2014 оны 1 дүгээр сарын 01-нээс мөрдөж эхэлнэ. Хуульчдын холбооны анхдугаар Их хурал завсарласнаас хойш арав хоногийн дотор www.jurists.gov.mn цахим системийн тусламжтайгаар Шүүхийн захиргааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4 –д заасан шаардлагыг хангасан, 60 нас хүрээгүй хуульч нэрээ дэвшүүлж, Их хурлын төлөөлөгчид цахим сонгуулиар зургаан шүүгч, гурван хуульчийг Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнд санал болгоно. Сонгуулийн дүнг Ерөнхийлөгч баталгаажуулан Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

8.Мэргэжлийн хариуцлагын хорооны шүүгч гишүүнээр ажиллахаар хүсэлтээ гаргасан хуульчдаас прокурор, өмгөөлөгчдийн хорооны гишүүд, прокурор гишүүнд шүүгч, өмгөөлөгчдийн хорооны гишүүд, өмгөөлөгч гишүүнд шүүгч, прокурорын хорооны гишүүд санал өгч, олонхын саналаар нэр дэвшүүлнэ. Хуульч хүсэлтээ гаргах, хороод нэр дэвшүүлэх ажлыг www.jurists.gov.mn цахим системийн тусламжтайгаар явуулна.

9.Сайн дурын хороо төлөөллөө сонгох үйл ажиллагаанд Хуульчдийн холбооны бүтцийн байгууллагад сонгууль явуулах нийтлэг журам үйлчилнэ. Уг журамд нийцээгүй тохиолдолд төлөөллийг батламжлахгүй бөгөөд тухайн асуудлыг дахин хэлэлцүүлэхээр тус хороонд буцаана.

10.Санал хураалтын тооллогын комиссын гишүүдийг Их хурлын явцад Хурлын зохион байгуулалтыг хангах багийн саналыг үндэслэн томилно.

--oOo--